

**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны 03 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Д/д	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ
1.Монгол Улсын хууль					
1	10.3 дахь хэсэг	Авлигын эсрэг хууль 2006.07.06	Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.	Үйлдвэрийн газрын хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 6 албан тушаалтны мэдүүлгийн хуулийн хугацаанд гаргуулан, бүртгэлд авч ажилласан.	99%
2	30 дугаар зүйл	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 2019.06.06	Хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах нийтлэг үүрэг хүлээнэ:	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүргийн дагуу “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын 2025 оны төлөвлөгөө” батлан гэмт хэрэг, зөрчил гарч буй шалтгаан нөхцөлийг тодруулж, түүний мөрөөр урьдчилан сэргийлэх арга хэмжээ аван холбогдох захиргааны байгууллага, төрийн тусгай албатай хамтран сургалт, сурталчилгаа мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрхийн үр дагаварт зам тээврийн ослын тоо болон эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн гаралт	99%

				буурах болгоомжгүй гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна.	
3	5 дугаар зүйл 4 дүгээр зүйл	Жолоочийн даатгалын тухай 2011.10.06	5.1.Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал даатгуулна. 4.1.2.хохирогчид нөхөн төлбөр олгох;	Нийтийн тээврийн автобусны жолооч нь хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт холбогдох, зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд холбогдож бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөрийг хуулийн дагуу барагдуулж байна. 3,612,251 төгрөгийг хохирол барагдуулсан.	99%
4	16 дугаар зүйл	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай 1995.04.17	1.Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.	ННЗБ системд 103 өргөдөл, гомдол бүртгэгдсэн ба өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 18 цаг бөгөөд хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэ ба уг хугацаанд 2 зөрчил бүртгэгдсэн байна.	99%
5	20 дугаар зүйл	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996.05.27	4/ үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;	Үйлдвэрийн газрын дарга өөрт олгогдсон эрх, үүргийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаандаа уг хуулийг удирдлага болгон хэрэгжүүлж үйл ажиллагааны үндсэн чиглэлээр (А) , хүний нөөцийн чиглэлээр (Б) 137 тушаал гарган хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.	99%

6	10 дугаар зүйл	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 2023.06.16	10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна.	Үйлдвэрийн газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрөө, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан иргэний гүйлгээнд оролцож 33 нээлттэй тендер зарлахаас 12 нээлттэй тендерийг цахимаар зарлан, үр дүн гарч 7 гэрээ байгуулагдсан байна.	99%
7	3 дугаар зүйл	Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.29	3.1.3.банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан;	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, батлуулж, 9 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган 2,9 тэр бум төгрөгийн хэмнэлт гаргаж 2025 оны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.	99%
8	3 дугаар зүйл	Хөдөлмөрийн тухай хууль 2021.07.02	3.4.Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар тусгайлан зохицуулаагүй төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг энэ хуулиар зохицуулна.	Үйлдвэрийн газар нь ажилтан, ажил олгогч нарын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэн, мөрдөн ажиллаж, иргэн хуулийн этгээдийн эрх ашиг сонирхлыг хамгаалан, үйлдвэрийн газарт ажиллаж буй 485 ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан.	99%
9	7 дугаар зүйл	Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2023.07.07	7.2.1.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан;	2025 оны II дугаар улирлын эхний хагас сарын байдлаар үйлдвэрийн газарт хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээний дагуу	99%

				ажиллаж байгаа ажилтныг албан журмын даатгалд хамруулж 1 дүгээр сард-495 ажилтны 417,578,401 төгрөгийг; 2 дугаар сард-494 ажилтны 416,331,133 төгрөгийг; 3 дугаар сард 485 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийн хуулийн хугацаанд тайлагнахаар ажиллаж байна.	
--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Ц.ЦЭНДСҮРЭН